

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХӨН ОЛГОВРЫГ
БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭР ОЛГООГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ,
ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ДАА-2022/38-ШТА-ГА



Дархан-Уул аймаг
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор Х.Сувдмаа

Утас: 70373089 Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор С.Санжаажав

Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70378845 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

Аудитор Ч.Гантулга

Утас: 70378845 Цахим хаяг: gantulgachu@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар

Утас: 70378845 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Аудитор Н.Отгонцэцэг

Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

Аудитор З.Мөнгөнцэцэг

Утас: 70378845 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

Аудитор О.Мягмарсүрэн

Утас: 70378845 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn

АГУУЛГА

БҮЛЭГ 1. Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх орон нутгийн дунд хугацааны бодлого, төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөр, зорилттой уялдсан байна	6
1.1.1. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийтийн тээврийн үйлчилгээний талаар 3 зорилт, 3 арга хэмжээ тусгагджээ	6
1.1.2. Зарим арга хэмжээг төлөвлөхдөө зорилт, хүрэх түвшнийг харилцан уялдаагүй боловсруулсан байна	7
1.1.3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг журамд нийцүүлэн бодитой үнэлээгүй байна	8
1.2.1. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч ААН-ийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна	8
1.2.2. Гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж байна	9
1.2.3. Талууд харилцан гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хэрэгжилтийг бодитой дүгнээгүй байна	9
БҮЛЭГ 2. Нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа жолооч, автотээврийн хэрэгсэл нь стандартын шаардлага хангахгүй байна	11
2.1.1 Эрх бүхий албан тушаалтан нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоож, батлаагүй байна	11
2.1.2 Нийтийн тээврийн үйлчилгээг тогтоосон чиглэлийн дагуу гүйцэтгэж байна	11
2.1.3. Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ, тариф нийслэлийн болон төвийн бүсийн аймгуудтай ойролцоо түвшинд байна	12
2.1.4. Тогтоосон чиглэл нь ирээдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна	13
2.2.2. Компанийн тээврийн хэрэгслийн 50 хувь нь стандартын шаардлага хангахгүй байна.	16
2.3.1. Нийтийн тээврийн төсвийн саналыг бодитой тооцоогүй байна	17
2.3.1. Нийтийн тээврийн үйлчилгээний нөхөн олговрыг бодит гүйцэтгэлээр тооцож олгоогүй байна	19
БҮЛЭГ 3. Нийтийн тээврийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна	20
3.1.1. “Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ нь гэрээнд заасан хяналтыг хэрэгжүүлсэн байна	20
3.1.2. Нийтийн тээврийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна	21
3.2. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна	21
3.2.1. Компанийн зүгээс техникийн ашиглалт, цаг ашиглалт зэрэгт өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлжээ	21
3.2.2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөн олговрын 1,875.4 сая төгрөгийн санхүүжилтийг байршуулаагүй байна	22
ДҮГНЭЛТ:	27
Хавсралт 1	29

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АХҮЧ	Аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МСҮТ	Мэргэжил, сургалт, үйлдвэрийн төв
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
ХАБЭА	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн жагсаалт	7
Хүснэгт 2	Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	8
Хүснэгт 3	Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй автобусны тоо	9
Хүснэгт 4	Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл	14
Хүснэгт 5	Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ, тарифын харьцуулсан судалгаа	15
Хүснэгт 6	Техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй болон ороогүй тээврийн хэрэгслийн жагсаалт	19
Хүснэгт 7	Нөхөн олговрын 2020, 2021 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв, тодотгол	20
Хүснэгт 8	Нөхөн олговрын 2020, 2021 оны төлөвлөлтийн тооцоо	20
Хүснэгт 9	Нийслэлийн нийтийн тээврийн нөхөн олговрын санхүүжилтийн судалгаа	22

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Нийтийн тээврийн зогсоолын байршил оновчтой эсэх	14
Дүрслэл 2	Иргэдээс авсан судалгааны үр дүн	15
Дүрслэл 3	“Д” ангиллын мэргэшсэн жолоочийн судалгаа	17

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол	16

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилго	Нийтийн тээврийн үйлчилгээ, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд: • Орон нутагт нийтийн тээврийн талаар баримтлах бодлого, шийдвэр үр дүнтэй хэрэгжсэн үү? • Нийтийн тээврийн үйл ажиллагаа үр дүнтэй байна уу? • Компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж байна уу?
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, Дархан сумын ЗДТГ, ИТХ, аймгийн МХГ, Автотээврийн төв, Цагдаагийн газар, “Элит хөгжил” ХХК-ийн 2020, 2021 оны үйл ажиллагаа болон бусад холбогдох байгууллагуудыг хамарсан болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, МУЕА-ын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2021 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Батсүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор С.Батцэцэг, Х.Сувдмаа, С.Санжаажав, аудитор Ч.Гантулга, Б.Алтанзул, Г.Батмягмар, Н.Отгонцэцэг, З.Мөнгөнцэцэг, О.Мягмарсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх орон нутгийн дунд хугацааны бодлого, төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөр, зорилттой уялдсан байна

1.1.1. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийтийн тээврийн үйлчилгээний талаар 3 зорилт, 3 арга хэмжээ тусгагджээ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлээр “Нийтийн тээврийн үйлчилгээ нэвтэрсэн хот, суурин газрын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид гэр, сургуулийнхаа хооронд нийтийн тээврээр үнэгүй зорчдог болно”, “Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ” зорилтуудыг төлөвлөсөн бол 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ” гэсэн зорилтыг хэрэгжүүлэхээр баталжээ.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.2, 6.8.3-т заасны дагуу Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг дараах байдлаар тус тус баталжээ.

Хүснэгт 1. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн жагсаалт

Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
3.2.11. Иргэдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.	2.5.2. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. /ЗГҮАХ 3.6.3, АХҮЧ 4.4.2/

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2016 оны 3/03, 2020 оны 2/08 дугаар тогтоол

Аудитаар нийтийн тээврийн үйлчилгээний талаар Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан эсэх, уялдааг хангасан эсэхийг зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийхэд Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 1 зорилт, 1 арга хэмжээ, 2021-2024 онд 2 зорилт, 2 арга хэмжээг тус тус уялдуулан төлөвлөсөн байна. Харин Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Нийтийн тээврийн үйлчилгээ нэвтэрсэн хот, суурин газрын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид гэр, сургуулийнхаа хооронд нийтийн тээврээр үнэгүй зорчдог болно” хөтөлбөрийг төлөвлөөгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1¹-т заасны дагуу аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийг 2021 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд нийтийн тээврийн үйлчилгээний талаар тусгаагүй байна.

¹ “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь ... Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх”

1.1.2. Зарим арга хэмжээг төлөвлөхдөө зорилт, хүрэх түвшнийг харилцан уялдаагүй боловсруулсан байна

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Дархан хотын доторх нийтийн тээврийн том оврын автобусны үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, алслагдсан гэр хорооллын чиглэлд явуулна” гэсэн арга хэмжээг төлөвлөж, Дархан сумын Засаг даргын 2017 оны А/191 дүгээр захирамжаар “Мангирт-Толгойт”, Дархан сумын Засаг даргын 2019 оны А/196 дугаар захирамжаар “Ширээ нуруу-Зах”, “Хөтөл хороолол-Толгойт”, “Мангирт-Вокзал” зэрэг чиглэлд маршрут баталж, алслагдсан гэр хорооллын иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж эхэлжээ.

Харин аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.2.1-ийн “... нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг систем нэвтрүүлэх ...” зорилтыг арга хэмжээ, хүрэх түвшинд тусгаагүй, хүрэх түвшнийг суурь түвшинтэй уялдуулж төлөвлөөгүй байна.

Хүснэгт 2. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Суурь түвшин	2021	2022	2023	2024	Хэрэгжүүлэгч байгууллага
			Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	
Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, тээврийн үйлчилгээг хөгжүүлж, <u>нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг систем нэвтрүүлэн</u> , алслагдсан гэр хорооллын чиглэлд үйлчилгээг өргөжүүлнэ.	Гэр хороолол руу нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Алслагдсан баг, хорооллын 3-н чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна.	Ширээ нуруу, Мангирт, Толгойт чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Ширээ нуруу, Мангирт, Толгойт чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Ширээ нуруу, Мангирт, Хабитат, Толгойт, Хөтөл хороолол чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Ширээ нуруу, Мангирт, Хабитат, Толгойт, Хөтөл хороолол чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Аймгийн ЗДТГ
Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолуудын тохижилтыг хийнэ.	Нийтийн тээврийн хэрэгслийн 15 зогсоолын тохижилтыг хийнэ.	Нийтийн тээврийн 68 зогсоолоос 10 зогсоол нь стандартад нийцсэн.	-	Нийтийн тээврийн 5 зогсоолыг стандартад нийцүүлэн тохижуулна.	Нийтийн тээврийн 5 зогсоолыг стандартад нийцүүлэн тохижуулна.	Нийтийн тээврийн 5 зогсоолыг стандартад нийцүүлэн тохижуулна.	Аймгийн ЗДТГ

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/132 захирамж

Аудитаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт бүрэн хэрэгжсэн эсэхийг шалгахад нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг систем нэвтрүүлэх зорилт хэрэгжээгүй, 2021 оны хэрэгжилтийг суурь түвшнээр тайлагнасан.

Хүснэгт 3. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй автобусны тоо

№	Маршрут	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Дархан зах-ширээ нуруу	3	3	2	2
2	Мангирт-Вокзал /2021 оноос-Мангирт-Хабитат/	1	1	1	1
3	Хөтөл-толгойт	3	3	1	1
4	Үйлчилгээний төв-Дархан сумын ЗДТГ	6	6	4	4
Нийт		13	13	8	8

Эх сурвалж: “Элит хөгжил” ХХК-аас ирүүлсэн судалгаа

Дээрх судалгаанаас харахад гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан ч үйлчилгээ үзүүлж буй автобусны тоо сүүлийн 2 жилд 38.5 хувиар буурсан байна.

1.1.3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг журамд нийцүүлэн бодитой үнэлээгүй байна

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийтийн тээврийн үйлчилгээний талаар 3 зорилт, арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар үнэлжээ.

Аудитаар дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний журмын дагуу үнэлсэн эсэхийг тулган шалгахад 2017-2020 оны зорилт, арга хэмжээг бодитой үнэлж, харин 2021 оны хэрэгжилтийг суурь түвшнээр тайлагнасан байхад 100 хувиар үнэлсэн нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.2.5-д “төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2.1. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч ААН-ийг ТБОНӨХБАУХА тухай хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна

Аймгийн Засаг дарга Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1²-д заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэгчтэй нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх хамтран ажиллах гэрээ, хэлцлийг байгуулжээ. Үүнд:

- Дархан хот доторх нийтийн тээвэрт хамтарч ажиллах гэрээ 2020-А/001
- Зорчигч тээвэрлэлтийн гэрээ ЗТГ 2020/008, ЗТГ 2021/01-09-01/
- Дархан хот доторх нийтийн тээвэрт хамтарч ажиллах гэрээ 2020-А/001-ийн нэмэлт “Санхүүжилтийн гэрээ”
- Дархан хотын алслагдсан баг хорооллын хүүхдүүдэд зориулсан автобусны тусгай үйлчилгээ үзүүлэх гэрээ ДА-2020-001, ДА-2021-001

Аудитаар дээрх гэрээнүүд нь хууль, журамд нийцсэн эсэхийг шалгуур үзүүлэлттэй тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдтэй гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАУХА тухай хуулийн дагуу тендер, сонгон шалгаруулалт

² Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь автотээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

зарлалгүйгээр гэрээ байгуулсан. Энэ нь хуулийн 3 дугаар зүйлийн 3.1³, 17 дугаар зүйлийн 17.1⁴-д заасантай нийцэхгүй байна.

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 1-1/5554 тоот албан бичгээр аймгийн ИТХ-ын 2019 оны 15/04 тоот тогтоолоор баталсан “Дархан хотын дотор нийтийн тээврийн хэрэгсэл /автобус/-ээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдийн нөхөн олговор болон үйлчилгээний зардлыг үндэслэн татаас олгох, хуваарилах, санхүүжүүлэх журам”-ыг хүчингүй болгож, холбогдох хуульд нийцүүлэн журмыг дахин хянуулахыг зөвлөсөн ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 03 тоот тогтоолоор нийтийн тээвэрт олгох санхүүжилтийг бууруулан баталсантай холбогдуулж санхүүжилтийн гэрээнд өөрчлөлт оруулаагүй байна.
- Хамтран ажиллах 2020-2021 оны гэрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор хүчингүй болсон 2005 оны 127 дугаар тогтоолыг тусгасан

Түүнчлэн хамтарч ажиллах гэрээний бүрдэл, гэрээнд тусгасан дагаж мөрдөх дүрэм, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний маршрутыг хавсаргаагүй нь гэрээний 8.2-т “Батлагдсан маршрутын зураглалыг гэрээнд хавсаргана” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2.2. Гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж байна

Хамтран ажиллах гэрээний 9.1-т “Тээвэрлэгч тал гэрээний үүргийн биелэлтийг гаргаж, гэрээний хугацаа дуусахаас ажлын 5 хоногийн өмнө захиалагч, хэрэгжүүлэгч талд хүргүүлнэ” гэж заасан ч “Элит хөгжил” ХХК-аас аймгийн ХБТХОХ-т ирүүлсэн тайлан, баримт материал байхгүй байна.

Харин “Элит хөгжил” ХХК нь сар болгоны 5-ны өдрийн дотор “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-т шугамын автобусны хөдөлгөөний бүртгэл, замын хуудсыг ирүүлснээр “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын тээврийн инженер өгсөн албан даалгаврыг үндэслэн өөрийн байгууллагын 2 диспетчерүүдийн шугамын автобусны хөдөлгөөний бүртгэлийг аймгийн ХБТХОХ-т хүргүүлж тайлагнадаг байна.

1.2.3. Талууд харилцан гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хэрэгжилтийг бодитой дүгнээгүй байна

Аймгийн ХБТХОХ-ээс хамтарч ажиллах болон санхүүжилтийн гэрээний хэрэгжилтийг 2020 онд 76, 2021 онд 77.6 хувьтай дүгнэжээ.

Аудитаар Дархан хот доторх нийтийн тээвэрт хамтарч ажиллах гэрээ болон санхүүжилтийн гэрээг дүгнэсэн акттай тулган шалгахад захиалагч, хэрэгжүүлэгч, тээвэрлэгч талын 27 үүргийг тус бүрээр нь биелэлтийг дүгнээгүй байна.

Дээрх гэрээнүүдээр хүлээсэн зарим үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Хамтран ажиллах гэрээний 4.1-т “Тээвэрлэлтийн явц байдалд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг аймгийн ХБТХОХ,

³ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

⁴ Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана

СТСХ, “Дархан орон нутгийн тээвэр” ОНӨААТҮГ хамтран хийж, илэрсэн зөрчлийг арилгах давтан гаргахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулаагүй”;

- Гэрээний 4.2-т “Хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, стандарт хангасан зогсоол, буудал, тэмдэг, тэмдэглэгээгээр бүрэн хангах талаар хамтарч ажиллах” гэсэнд тээврийн хэрэгслийн тэмдэг, тэмдэглэгээг тогтоосон чиглэлийн цэгүүдэд байршуулаагүй;
- Гэрээний 4.6-д “Тээвэрлэлтийн талаар удирдах дээд байгууллага болон холбогдох байгууллагуудаас ирүүлсэн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан тээвэрлэгчдийг мэдээ мэдээллээр хангах” ажил хийгдээгүй;
- Гэрээний 6.3-т “Аймгийн ЗДТГ-ын Web сайтад үйлчилгээний маршрут, хамт олны зураг, бүтэц зохион байгуулалт болон түүхэн замнал, товч танилцуулга, зорилго зорилтыг байрлуулах” гэснийг хэрэгжүүлээгүй;
- Гэрээний 6.4-т “Тээврийн хэрэгслүүдэд чиглэлийн хаяг, эмблем, паркийн дугаар, замнал, зогсоол буудлын нэр болон үнэ тариф, санамж зөвлөмж, сануулгыг зорчигчдод ил харагдахаар газарт стандартын дагуу байрлуулсан байх” гэсэн ч нийтийн тээврийн хэрэгсэл дотор чиглэл, замналын зураглал, тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг заалт, осол аюулын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, шуурхай арга хэмжээний бүдүүвч зургийг байрлуулаагүй;
- Гэрээний 6.6-т “Тээвэрлэгч жолооч, иргэд зорчигч нарт холбогдох хууль тогтоомж, стандартын талаар байнга мэдээлэл өгөх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах” ажил хангалттай хийгдээгүй;
- Санхүүжилтийн гэрээний 4.1.1-т “Дархан хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагааг бодлого, арга зүйн хувьд мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах” гэж заасан ч одоог хүртэл бодлого, арга зүйг боловсруулаагүй;
- Гэрээний 3.5⁵, 5.5-д “Тээвэрлэгч байгууллага нь зорчих тасалбараар үйлчилж, цахим картад үе шаттайгаар шилжих” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Харин зорчигч тээвэрлэлт болон Дархан хотын алслагдсан баг хорооллын хүүхдүүдэд зориулсан автобусны тусгай үйлчилгээ үзүүлэх гэрээнүүдийг дүгнээгүй байна.

Дээрхээс үзэхэд захиалагч, хэрэгжүүлэгч талууд харилцан гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хэрэгжилтийг бодитой дүгнээгүй байна.

⁵ Нийтийн тээвэрээр үйлчлүүлсэн зорилтот бүлгийн иргэдийн тээвэрлэлтийн нөхөн олговрыг тээвэрлэгч байгууллагад олгохдоо ухаалаг төлбөрийн системээр хяналт тавьж эхлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ

БҮЛЭГ 2. Нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа жолооч, автотээврийн хэрэгсэл нь стандартын шаардлага хангахгүй байна

2.1.1 Эрх бүхий албан тушаалтан нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоож, батлаагүй байна

Дархан сумын Засаг дарга “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.б⁶, 29.1.6.к⁷, 29.2⁸, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2014 оны 175⁹ дугаар захирамжийн 2 дахь хэсэг¹⁰-т заасны дагуу 2019 оны А/196 дугаар захирамжаар “Толгойт-Хөтөл хороолол”, “Мангирт-Вокзал” чиглэлийг, 2020 онд А/38 дугаар захирамжаар “Үйлчилгээний төв-Дархан сумын ЗДТГ”, “Тосгон-Ширээ нуруу”, “Төмөр зам-Мангирт”, “Толгойт-Хөтөл” чиглэлийг, А/61 дүгээр захирамжаар “Ширээ нуруу-Зах” чиглэлийг тус тус баталсан байна.

Дархан сумын Засаг дарга 2021 онд баталсан “Бирж-Ширээ нуруу”, “Мангирт-Хабитат” чиглэлийг захирамжлалын баримт бичгээр батлаагүй байна. Энэ нь Дархан-Уул аймгийн Засаг дарга, “Элит хөгжил” ХХК, “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын хамтарсан 2020 оны 2020-А/001 дугаартай “Дархан хотын доторх нийтийн тээвэрт хамтарч ажиллах гэрээ”-ний 2.2¹¹, 8.2¹² дахь заалттай нийцэхгүй байна. Мөн хүүхдийн автобусны 5 чиглэлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тогтоож, батлаагүй нь 2020 оны ДА-2020-001 дугаартай “Дархан хотын алслагдсан баг хорооллын хүүхдүүдэд зориулсан автобусны үйлчилгээ үзүүлэх ажлын гэрээ”-ний 8.1¹³, “Автотээврийн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.4¹⁴ дэх хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.

2.1.2 Нийтийн тээврийн үйлчилгээг тогтоосон чиглэлийн дагуу гүйцэтгэж байна

Дархан хотын нийтийн тээврийн үйлчилгээг 4 чиглэл, 109 цэгт зогсолт хийхээр баталжээ.

Тогтоосон чиглэлд зам засвар болон цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөлт орсон тохиолдолд “Элит хөгжил” ХХК нь өөрийн цахим хаягаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээллийг цаг тухай бүр хүргэдэг байна.

Аудитаар нийтийн тээврийн үйлчилгээний баталсан чиглэл, тогтоосон цэгт зогсолт хийж байгаа эсэхэд ажиглалт хийхэд “Бирж-Ширээ нуруу” чиглэлд нефть бааз, 15 дугаар сургуулийн цэгт зогсдоггүй, “Мангирт-Хабитат” чиглэлд тусгагдаагүй “Дархан сод эрдэнэ” дэлгүүрийн автобусны буудалд зогсдогоос гадна тухайн чиглэлд 1 рейст зарцуулах хугацаа нь 20 минутаар илүү байна.

⁶ Өмчийн бүх төрөл, хэлбэрт тулгуурлан харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амын тээврийн үйлчилгээний хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулах, уг үйлчилгээнд дагаж мөрдөх журам, стандартын биелэлтийг хангуулах

⁷ Засгийн газраас аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг даргаас сум, дүүргийн Засаг даргад хууль тогтоомжид заасны дагуу шилжүүлсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх

⁸ Засаг дарга эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

⁹ Нийтийн тээврийн үйлчилгээнд том оврын

¹⁰ Автобусны үйлчилгээний маршрут, цагийн хуваарь, үнэ тарифыг зохих журмын дагуу баталж мөрдүүлэхийг Дархан сумын Засаг дарга /Б.Азжаргал/-д зөвшөөрсүгэй.

¹¹ Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний маршрут нь гэрээний хавсралтаар батлагдах бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

¹² Батлагдсан маршрутын зураглалыг гэрээнд хавсралтаар тусгана.

¹³ Батлагдсан маршрутын зураглалыг гэрээнд хавсралтаар тусгана.

¹⁴ Аймаг хооронд, орон нутаг, аймгийн төв, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, хотын Засаг дарга гаргах бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын эрх олгосон байгууллага хэрэгжүүлнэ.


Хүснэгт 4. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл

№	Чиглэл	Нийт км	Буудлын тоо		Чиглэлд зарцуулах хугацаа /минутаар/	
			Батлагдсан чиглэлээр	Аудитаар	Батлагдсан чиглэлээр	Аудитаар
1	Үйлчилгээний төв-Сумын ЗДТГ	28	30	30	60	60
2	Бирж-Ширээ нуруу	16	25	23	60	60
3	Мангирт-Хабитат	14	28	29	40	60
4	Толгойт-Хөтөл хороолол	14	26	30	60	60
5	16-р сургууль-Ширээ нуруу	14	16	16	60	60
6	Хөтөл хороолол-1-р сургууль	8	18	18	60	60
7	Хабитат-ОИЦ сургууль	7	20	20	60	60
8	Мангирт-ОИЦ сургууль	7	18	18	50	50
9	Толгойт-1-р сургууль	8	15	15	50	50

Эх сурвалж: Тогтоосон чиглэлийн зураглал

Дээрх хүснэгтээс харахад нийтийн тээврийн үйлчилгээг тогтоосон чиглэлийн дагуу гүйцэтгэж байгаа нь харагдаж байна. Харин алслагдсан гэр хорооллын дундах автобусны чиглэлийн дагуух замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулаагүй байгаа нь “Замын хөдөлгөөний дүрэм”-ийн нэгдүгээр хавсралтын 5.21¹⁵, 2020 оны “Дархан хотын нийтийн тээвэрт хамтарч ажиллах гэрээ”-ний 4.2¹⁶-д заасантай нийцээгүй бөгөөд аудитаар тулган баталгаажуулалт хийхэд хүндрэлтэй байлаа.

Дүрслэл 1. Нийтийн тээврийн зогсоолын байршил оновчтой эсэх



Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч “Элит хөгжил” ХХК нь 2022 оны байдлаар Дархан сум дотор 4 чиглэлд 8 автобусаар үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд иргэдээс нийтийн тээврийн зогсоолын байршлын талаар судалгаа авахад нийт оролцогчдын 80 хувь нь тийм буюу оновчтой байна гэж хариулсан.

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

Нийтийн тээврийн тогтоосон чиглэлд холбогдох өөрчлөлтийг тусган шинэчлэн батлах, зогсоолын байршил, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байгаа нь харагдаж байна.

2.1.3. Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ, тариф нийслэлийн болон төвийн бүсийн аймгуудтай ойролцоо түвшинд байна

Дархан-Уул аймагт нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлсэнтэй холбогдуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Дархан хотын нийтийн тээврийн хэрэгсэл /автобус/-ийн үйлчилгээний үнэ, тариф”-ыг баталжээ.

Аудитаар нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тариф үндэслэлтэй байгаа эсэхийг шалгахад ямар нэгэн тооцоолол, судалгаа байгаагүй бөгөөд такси

¹⁵ Чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал

¹⁶ Хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж стандарт хангасан зогсоол буудал, тэмдэг, тэмдэглэгээг бүрэн хангах талаар хамтарч ажиллах

үйлчилгээний үнээс 50 хувиар бага буюу том хүн 500 төгрөг, хүүхэд 300 төгрөг байхаар тогтоосон байна. Энэ нь Автотээврийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ хөлсний хэмжээг оролцогч талуудын тохиролцож байгуулсан гэрээгээр тогтооно” гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт 5. Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ, тарифын харьцуулсан судалгаа

Аймаг, хот	Үнэ тариф	
	Том хүн	Хүүхэд
Улаанбаатар хот	500	300
Орхон аймаг	600	400
Төв аймаг	500	200

Үүнийг Улаанбаатар хот, төвийн бүсийн 2 аймгийн үнэ, тарифтай харьцуулахад ойролцоо түвшинд байна.

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоолууд

2.1.4. Тогтоосон чиглэл нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна

Дархан хот доторх нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор иргэдээс судалгаа авч нэгтгэн дүгнэлээ.

Судалгаанд нийт 82 иргэн хамруулснаас 41 хувь нь ахмад настан, 7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 24 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг, 28 хувь нь оюутан, сурагчид байлаа.

Дүрслэл 2. Иргэдээс авсан судалгааны үр дүн



Дүрслэлээс харахад иргэд автобусны тогтоосон чиглэл нь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа боловч баталсан зогсоолын цэгийн байгууламж хангалтгүй гэж асуулгад хариулжээ.

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

Аудитаар автобусны зогсоолууд нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартыг шаардлагыг хангаж байгаа эсэхийг тулган шалгахад 1-р чиглэлийн 30 зогсоолоос 10, 2-р чиглэлийн 25 зогсоолоос 6, 3-р чиглэлийн 28 зогсоолоос 7, 4-р

чиглэлийн 26 зогсоолоос 8 зогсоол MNS 5879:2012 стандартын 4.4¹⁷, 4.7¹⁸, 6.3¹⁹, 7.6²⁰-д заасан шаардлагыг хангахгүй байна.

Зураг 1. Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол



Мөн нийтийн тээврийн бүх зогсоолд зогсоолын нэр, дайран өнгөрөх замналын дугаар, зураглал, цагийн хуваарь болон нийтийн тээврийн холбогдох бусад мэдээлэл байгаагүй нь стандартын 4.9²¹-тэй тус тус нийцэхгүй байна. Дээрх судалгаа, ажиглалтаас зогсоолуудад нэр, цагийн хуваарь, дайран өнгөрөх замналын дугаар, зураглалыг багтаасан мэдээллийн самбар байхгүй нь иргэд автобусыг удаан хугацаагаар хүлээхэд хүргэдэг гэж дүгнэж болохоор байна. Иймд зогсоолуудыг MNS 5879:2012 стандартад нийцүүлэх ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.2.1. Жолооч нарын 75 хувь нь зорчигч тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн эрхгүй байгаа нь стандартад нийцэхгүй байна

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 74 дүгээр тогтоолоор MNS 5012:2011, Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/65 тоот тушаалаар MNS5012:2021 стандартаар нийтийн тээврийн үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагыг баталсан.

Аудитаар “Элит хөгжил” ХХК-ийн нийтийн тээврийн чиглэлд 4, сурагчдын 4, нийт 8 автобусыг түүвэрт хамруулан MNS5012:2021 стандартаас нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагад тавих 9, үйлчилгээнд тавих 11, байгууллагын хүний нөөцөд тавих 7, нийт 27 стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тулган шалгаж, иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авлаа.

Түүвэрт хамрагдсан автобусанд ажиглалт хийхэд нийтийн тээврийн үйлчилгээний автобус нь тусгай хаягтай байх, хурд хэтрүүлэх, хэт удаан явах, багтаамжаас илүү хүн шахаж суулгахгүй байх, зориулалтын суудлын бүрэн бүтэн байдал, бариул гэрэлтүүлэг, дулаацуулах систем, зорчих дүрэм, санамжуудыг байршуулах, үйлчилгээнд гарахын өмнө дотор, гадна талыг угаалгаж, зорчигчдын

¹⁷ 4.4. Зогсоолын байгууламж-Замын хөдөлгөөний урсгалд үл хамаарах автозамын хажуугийн зогсоолын талбай, зорчигч зогсох талбай, мэдээллийн самбар, хогийн сав, сандал, саравч, орчны гэрэлтүүлэг бүхий зогсоолын иж бүрдэл.

¹⁸ 4.7. Зогсоолын талбай-Зорчигч суух, буухад зориулсан автозамын хөдөлгөөний урсгалд үл хамаарах зогсоолын хажуугийн хэсэг.

¹⁹ 6.3. Зогсоолын зэрэглэлээр түүний байгууламж.

²⁰ 7.6. Замналын дундын зогсоол нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, зорчигчийн тав тухтай зорчих нөхцөл шаардлагыг хангасан байна.

²¹ 4.9. Мэдээллийн самбар-Зогсоолын нэр, дайран өнгөрөх замналын дугаар, нэр, зураглал, цагийн хуваарь болон нийтийн тээврийн холбогдолтой бусад мэдээллийг агуулсан самбар.

суудал, түшлэг, бариул зэргийг арчиж бүрэн цэвэрлэгээ хийлгэж байх стандартуудыг хангаж байна.


Харин нийтийн тээврийн үйлчилгээнд тавигдах дараах шаардлага, стандартыг хангахгүй байгаа зөрчил илэрлээ. Үүнд:

- Жолооч нарыг үйлчилгээнд гарахын өмнө эмчийн үзлэгт хамруулдаггүй
- Хүний нөөцийн мэдээллийг “Зам тээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем”-д бүртгээгүй
- Барилга байгууламж болон автотээврийн хэрэгсэлд байгаа 34 ширхэг гал унтраагуурын ашиглалтын хугацаа дууссан
- Осол, аюулын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, шуурхай арга хэмжээний бүдүүвчгүй
- Нийтийн тээврийн хэрэгсэл дотор чиглэл, замналын зураглал, тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг заалт байхгүй
- Жолооч, кондукторын түр амрах, хооллох байргүй зэрэг нь нийтийн тээврийн үйлчилгээнд тавих MNS5012:2021 стандартын 6 дугаар зүйлийн 6.9²², 6.11²³, 7 дугаар зүйлийн 7.7²⁴, 7.8²⁵, 9 дүгээр зүйлийн 9.4.4²⁶, 9.5²⁷ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Нийтийн тээврийн үйлчилгээ нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэхийг 82 иргэнээс авсан судалгаагаар дүгнэхэд 75.6 хувь нь “тийм” буюу хангаж байна, 24.4 хувь нь “үгүй” буюу хангахгүй гэж хариулсан нь үйлчилгээг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

“Элит хөгжил” ХХК-ийн нийтийн тээврийн болон сурагчдын автобус үйлчилгээнд явдаг тээврийн хэрэгслийн нийт 16 жолоочийг мэргэжил, мэргэшлийн шаардлага хангасан эсэхийг Дархан-Уул аймгийн Автотээврийн төвийн мэдээллийн сантай тулгахад бүх жолооч “Д” ангилалтай, 4 нь мэргэшсэн жолоочийн эрхтэй байлаа: Үүний дүрслэл 3-аар харуулбал:

Дүрслэл 3. “Д” ангиллын мэргэшсэн жолоочийн судалгаа



Үзүүлэлтээс харахад нийт 16 жолоочийн 4 буюу 25 хувь нь мэргэшсэн жолооч, 3 буюу 19 хувь нь мэргэшсэн жолоочийн хугацаа дууссан, 9 буюу 56 хувь нь мэргэшсэн жолоочийн эрхгүй байна.

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн Автотээврийн төв

Мэргэшсэн жолоочийн эрхгүй болон хугацаа дууссан жолооч нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа нь Автотээврийн тухай хуулийн 19 дүгээр

²² Нийтийн тээврийн хэрэгсэл дотор чиглэл, замналын зураглал,тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг заалтыг стандартын дагуу байрлуулсан байна.

²³ Осол, аюулын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, холбогдох байгууллага, хүмүүст яаралтай мэдэгдэх, өртөгсдөд анхны тусламж үзүүлэх, аврах шаардлагатай арга хэмжээ авах шуурхай арга хэмжээний бүдүүвчтэй байна.

²⁴ Ажилтнуудаа жил бүр эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт хамруулах ба жолооч нарыг үйлчилгээнд гарахын өмнө эмчийн үзлэгт заавал хамруулна

²⁵ Хүний нөөцийн мэдээллийг “Зам тээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем”-д заавал бүртгэлжүүлсэн байна.

²⁶ Галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.

²⁷ Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь замналын дагуух тодорхой цэгүүдэд жолооч, кондукторын түр амрах, хооллох байр, бие засах газруудыг MNS 5537 стандартын дагуу зохион байгуулна.

зүйлийн 19.1²⁸, 10 дугаар зүйлийн 10.2.2²⁹, MNS5012:2021 стандартын 11 дүгээр зүйлийн 11.2.1³⁰ дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

2.2.2. Компанийн тээврийн хэрэгслийн 50 хувь нь стандартын шаардлага хангахгүй байна.

Мэргэжлийн байгууллагаас “Элит хөгжил” ХХК-д , MNS 5012:2021, MNS 4601:2011, MNS 5025:2020, MNS 6595:2017, MNS 5342:2007, MNS 4598:2011 стандартын ерөнхий шаардлагуудыг хангасан гэж үзээд “Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм”-ийн 4.1.2.14³¹ дэх заалт, MNS 5012:2021 стандартын 7.4³²-т заасны дагуу нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тохирлын гэрчилгээ олгожээ.

Тээврийн хэрэгслийг MNS 5012:2011 стандартын 7.4³³ дэх хэсэгт үйлдвэрлэснээс хойш 12-оос дээш жил ашигласан бол нийтийн тээвэрт үйчилгээ үзүүлэхийг хориглосон байхад тохирлын гэрчилгээ олгосон нь ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 с/03, с/41 дүгээр тушаалаар стандартад нэмэлт өөрчлөлт оруулан тээврийн хэрэгслийн насжилтыг түр түдгэлзүүлсэн шийдвэр гарсантай холбоотой байна.

Аудитаар нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа том оврын 20 автобуснууд нь холбогдох хууль, дүрэм, стандартад нийцсэн эсэхийг тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Бүх автобуснууд нь 12-оос дээш жилийн насжилттай /Тулган баталгаажуулалтаар/
- Техникийн хяналтын үзлэгээр тэнцээгүй 2 автобус /Автотээврийн төвөөс авсан судалгаагаар/
- Гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтад ороогүй 7 автобус /Автотээврийн төвөөс авсан судалгаагаар/
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тоноглолгүй /Ажиглалтаар/
- Сурагч тээврийн автобус нь стандартын шаардлага хангаагүй /Ажиглалтаар/

Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011 стандартын дагуу Дархан-Уул аймгийн Автотээврийн төвөөс судалгаа авахад техникийн үзлэгт тэнцээгүй болон ороогүй нийт 9 тээврийн хэрэгсэл байлаа.

Хүснэгт 6. Техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй болон ороогүй тээврийн хэрэгслийн жагсаалт

Д/Д	Гражийн дугаар	Улсын дугаар	Авто машины марк	Үйлдвэрлэсэн он	Өнгө	Тайлбар
1	0-6	61-95 ДАХ	DAEWOO BS090	2007 он	Цэнхэр алаг	2022 онд үзлэгт ороогүй
2	0-7	74-31 УНВ	DAEWOO	2007 он	Цагаан	2022 онд тэнцээгүй

²⁸ “Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан тээвэрлэлтийг гүйцэтгэхэд зохих ангиллын автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийг ажиллуулна

²⁹ тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг тухайн ангиллын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх

³⁰ Жолооч нь автобусны жолооч бэлтгэх сургалтыг дүүргэсэн, жолоочийн мэргэжлийн “Д” ангилалтай, мэргэшсэн жолооч байна”,

³¹ зорчигч тээврийн үйлчилгээнд итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулалт хийлгэн, “тохирлын гэрчилгээ” авсан аж ахуйн нэгж, байгууллагыг сонгох, үйлчилгээг гүйцэтгүүлнэ;

³² Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх байгууллага нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу тохирлын үнэлгээ хийлгэж гэрчилгээ авсан байна

³³ Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд үйлдвэрлэснээс хойш 12-оос дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно.

			BS106		алаг	
3	0-10	93-21 ДАР	HYUNDAI AERO CITY 540	2009 он	Цагаан алаг	2022 онд тэнцээгүй
4	0-11	39-69 УБЭ	AERO CITY	2007 он	Цэнхэр	2021, 2022 онд үзлэгт ороогүй
5	0-17	62-49 УНВ	AERO CITY	2007 он	Цэнхэр	2021, 2022 онд үзлэгт ороогүй
6	0-21	29-99 ДАУ /Хүүхэд/	HYUNDAI AERO CITY	2012 он	Ногоон алаг	2022 оны 9 дүгээр сарын 23-нд хугацаа дууссан
7	0-22	98-10 ДАР /Хүүхэд/	HYUNDAI COUNTY	2005 он	Шаргал	2022 оны 9 дүгээр сарын 23-нд хугацаа дууссан
8	0-23	49-99 ДАУ /Хүүхэд/	HYUNDAI AERO CITY	2012 он	Ногоон алаг	2022 оны 9 дүгээр сарын 23-нд хугацаа дууссан
9	0-24	98-70 ДАР /Хүүхэд/	HYUNDAI AERO TOWN	2012 он	Шар	2022 оны 9 дүгээр сарын 23-нд хугацаа дууссан

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн Автотээврийн төв

Үүнээс үзэхэд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа тээврийн хэрэгслийн 50 хувь нь техникийн байдалд тавих ерөнхий шаардлага, стандартыг хангахгүй байна. Иймд нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт тогтмол оруулж байх, парк шинэчлэл хийх зэрэгт үйлчилгээ үзүүлэгч байгууллага анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.3.1. Нийтийн тээврийн төсвийн саналыг бодитой тооцоогүй байна

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5³⁴, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8³⁵, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.5³⁶, Цагдаагийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4³⁷ дэх заалтуудыг тус тус үндэслэн, иргэд нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих зардлын нөхөн олговрыг орон нутгийн төсвөөс “Элит хөгжил” ХХК-д олгож иржээ.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс хамтран нөхөн олговрын төсвийн саналыг 2020 онд 2,221.0 сая, 2021 онд 2,542.7 сая төгрөгөөр тооцсон байна.

Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020, 2021 оны төсөвт нийтийн тээврийн нөхөн олговрын төсвийн суурийг тайлант онуудад тус бүр 1,314.3 сая төгрөгөөр хянасан нь төсвийн саналаас 40.8 - 48.3 хувиар бууруулжээ.

Хүснэгт 7. Нөхөн олговрын 2020, 2021 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв, тодотгол
/сая төгрөгөөр/

³⁴ Ахмад настан нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих бөгөөд нийтийн тээврийн байгууллага ахмад настныг нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;

³⁵ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино. Энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг нийслэл, орон нутгийн төсөвт жил бүр тусган, хэрэгжүүлнэ.

³⁶ Нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ явах зайлшгүй шаардлагатай сурагч, оюутны нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зардлын 50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон журмын дагуу олгох

³⁷ Хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр үнэ төлбөргүй зорчих;

Үзүүлэлт	Он	Төсвийн төсөл	УИХ-ын баталсан төсөв	ИТХ-ын баталсан төсөв	Тодотгол-1	Тодотгол-2	Тодотгол-3	Тодотгол-4
Нөхөн олговор	2020	2,221.0	1,314.3	1,314.3	1,314.3	1,314.3		
	2021	2,542.7	1,314.3	1,289.3	1,289.3	1,289.3	1,059.3	1,059.3

Эх сурвалж: Сангийн яамны төсвийн хязгаар, Дархан-Уул аймгийн ИТХ-ын тогтоолууд

Аймгийн ИТХ-ын 2019 оны 15/07 дугаар тогтоолоор 2020 оны нийтийн тээврийн нөхөн олговрыг УИХ-аас хянаж ирүүлсэн суурь зарлагаас өөрчлөлгүйгээр хэвээр баталж, тухайн оны 2 тодотголоор мөн өөрчлөөгүй байна.

Харин 2021 онд нөхөн олговрыг аймгийн ИТХ ямар нэгэн тооцоо судалгаагүйгээр 25.0 сая төгрөг хасаж батлан, 9 дүгээр сарын тодотголоор хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурлан 230.0 сая төгрөгөөр бууруулжээ.

Аудитаар нөхөн олговрын төлөвлөлтийн тооцооллыг статистик тоо мэдээтэй тулган шалгахад 2020 онд ахмад настны тоог 2,149-ээр, МСҮТ-ийн сурагчдын тоог 3,137-оор илүү, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог 82-оор дутуу тооцсоноос нөхөн олговрыг 499.8 сая төгрөгөөр, 2021 онд ахмад настны тоог 910-аар илүү тооцсоноос нөхөн олговрыг 192.4 сая төгрөгөөр тус тус илүү тооцсон байв.

Хүснэгт 8. Нөхөн олговрын 2020, 2021 оны төлөвлөлтийн тооцоо

/сая төгрөгөөр/

№	Нэршил	2020 он			2021 он		
		төлөвлөсөн	аудитаар	зөрүү	төлөвлөсөн	аудитаар	зөрүү
1	оюутан	298.7	298.7	-	284.0	284.0	-
2	ахмад настан	1,111.4	783.4	(328.0)	1,519.3	1,326.9	(192.4)
3	ХБИ	484.8	497.3	12.5	524.5	524.5	-
4	сурагч	326.1	141.8	(184.3)	179.9	179.9	-
5	цагдаа	-	-	-	34.9	34.9	-
	Нийт дүн	2,221.0	1,721.2	(499.8)	2,542.6	2,350.2	(192.4)

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

Түүнчлэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс нийтийн тээврээр үйлчлүүлдэггүй хүний тоо, оюутан болон МСҮТ-ийн сурагчдын тойргийнхоо ойр орчимд суралцагсдын тоо, цагдаагийн албан хаагчийн тоог ямар эх сурвалжаас авсан нь баримтаар нотлогдоогүй болно.

Энэ нь төсвийн тооцоололд тавих удирдах албан тушаалтнуудын хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн сургуулийн сурагчдын автобусны үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 2020 онд 75.0 сая, 2021 онд 100.0 сая төгрөгийг баталжээ.

Сурагчдын автобусны санхүүжилтийн гэрээнд нэг автобусны хоногт олгох зардлыг 2020 онд 119,426.75 төгрөг, 2021 онд 147,058.82 төгрөг гэж тусгаснаас өөр төсөвлөлтийн тооцооллын баримт материал байгаагүй болно.

Аудитаар нийтийн тээврийн нөхөн олговор болон сурагчдын автобусны төсвийн саналыг бодитой төлөвлөөгүй байна гэж дүгнэлээ.

Иймд нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг систем ашиглаж, цахим картыг нэвтрүүлснээр зорчилт бүрийг тоолж, зорчсон тоогоор нөхөн олговрыг олгон, төлөвлөлтийг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн тооцоолох нь зүйтэй байна.

2.3.2. Нийтийн тээврийн үйлчилгээний нөхөн олговрыг бодит гүйцэтгэлээр тооцож олгоогүй байна

Дархан сум доторх нийтийн тээврийн үйлчилгээг аймгийн Засаг дарга, “Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ-тай байгуулсан хамтын гэрээний дагуу “Элит хөгжил” ХХК хэрэгжүүлжээ. Нийтийн тээврийн үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбогдуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 тогтоолоор “Дархан хотын дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдийн нөхөн олговрыг хуваарилах, санхүүжүүлэх” түр журам баталжээ.

Орон нутгийн төсвөөс хотын нийтийн тээврийн нөхөн олговорт 2020 онд 1,314.3 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 999.1 сая, 2021 онд 1,289.3 сая төгрөг баталж, тодотголоор 230.0 сая төгрөгөөр бууруулж, гүйцэтгэлээр 1,000.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитаар нийтийн тээврийн үйлчилгээнд олгосон нөхөн олговрыг хууль, журамд нийцүүлэн, бодиттой тооцсон эсэхийг анхан шатны баримттай тулган шалгахад хөнгөлөлттэй зорчсон иргэдийн тоогоор бус рейсийн төлөвлөгөөний биелэлтээр санхүүжилтийг олгожээ. Энэ нь Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.5³⁸, Цагдаагийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4³⁹, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-ын 4.4⁴⁰, 4.5⁴¹-д заасантай нийцэхгүй байна. Мөн нийтийн тээврийн үйл ажиллагаанд захиалагчийг төлөөлж хяналт хэрэгжүүлсэн “Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ-ын шугамын автобусны хөдөлгөөний бүртгэлийг аймгийн ХОХБТХ-ийн нөхөн олговрын баримттай тулган шалгахад 2020 онд рейсийн тоо 5,061, гүйцэтгэлийн хувь 17.3, 2021 онд рейсийн тоо 2,254, гүйцэтгэлийн хувь 6.5-аар илүү байлаа. Энэ нь тус газарт хянагддаггүй Мангирт-Хабитат, Хөтөл хороолол-Толгойт гэсэн 2 чиглэлийн гүйцэтгэлийг нэмж оруулсантай холбоотой байв. Дээрх нөхцөл байдал нь нийтийн тээврээр үйлчлүүлж байгаа нөхөн олговорт хамрагдах иргэдийг бүртгэх хяналтын систем байхгүй, зохицуулахаар боловсруулсан журам нь холбогдох хууль эрхийн акттай нийцээгүй зэрэгтэй шууд хамааралтай байна.

Аудитаар нийслэлийн нийтийн тээврийн нөхөн олговрын санхүүжилтийн талаар судалж үзэхэд нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих иргэдэд зориулж төсвөөс 2015 он хүртэл жил бүр 50 гаруй тэрбум төгрөг зарцуулж байсан бол 2016 оноос ухаалаг төлбөрийн болон бүртгэлийн систем нэвтрүүлснээр жилд 20 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан байна. Үүний хүснэгтээр харуулав.

Хүснэгт 9. Нийслэлийн нийтийн тээврийн нөхөн олговрын санхүүжилтийн судалгаа

/сая төгрөгөөр/

Нөхөн	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
-------	---------	---------	---------	---------	---------	---------

³⁸ нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ явах зайлшгүй шаардлагатай сурагч, оюутны нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зардлын 50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон журмын дагуу олгох;

³⁹ хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр үнэ төлбөргүй зорчих;

⁴⁰ Аймаг, нийслэлийн тээврийн газар тухайн сард цахим картаар үнэ төлбөргүй зорчсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчсон тоо, гүйцэтгэлийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр гаргаж, баталгаажуулсан тайланг дараа сарын 5-ны дотор багтаан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

⁴¹ Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар төсөвт тусгагдсан хөрөнгийг гүйцэтгэлийг нь үндэслэн орон нутгийн нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

олговрын төрөл						
Оюутан	28,837.6	28,722.1	28,722.1	8,910.3	4,655.4	7,312.2
Цагдаа	1,302.3	1,288.5	1,359.6	1,359.6	1,359.6	1,359.6
ХБИ/ахмад	23,062.7	29,362.7	23,062.6	25,856.9	24,535.0	25,856.7
Нийт дүн	53,202.6	59,373.3	53,144.3	36,126.8	30,550.0	34,528.5

Эх сурвалж: Өнөөдөр сонин

Дээрх тоон мэдээллээс харахад төлбөрийн болон бүртгэлийн ухаалаг системийг нэвтрүүлснээр нөхөн олговрын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох нөхцөл бүрджээ. Иймд үүссэн нөхцөл байдал, дээрх жишээнээс харахад нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг төлбөрийн болон бүртгэлийн систем нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дархан суманд анх 2015 оноос алслагдсан баг, хорооллын хүүхдүүдэд зориулан сурагчдыг хичээлдээ ирэх, буцах автобусны тусгай үйлчилгээг аймгийн Засаг дарга, “Элит хөгжил” ХХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж иржээ.

Дархан-Уул аймаг 2022 оныг “Хүүхэд хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулж орон нутгийн төсвийн хөрөнгөөр хүүхэд тээвэрлэх зориулалтын 4 автобус худалдан авч парк шинэчлэл хийсэн.

Тус үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 2020 онд 75.0 сая, 2021 онд 100.0 сая төгрөгийн нөхөн олговор олгохоор баталж, гүйцэтгэлээр 2020 онд 32.2 сая, 2021 онд 63.9 сая төгрөг тооцож олгожээ. Санхүүжилтийг тооцож олгохдоо сургуулиудаас гаргаж ирүүлсэн сурагч тээвэрлэлтийн бүртгэл, албан тоот зэргийг үндэслэн олгосон байна.

Аудитаар сурагчийн болон нийтийн тээврийн үйлчилгээнд явсан тээврийн хэрэгслүүдийн чиглэл, хугацааны хувьд давхардал үүссэн эсэхийг тулган шалгахад 2020 оны 1 сард 62-49 УНВ, 1, 9 сард 49-45 ДАХ улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийн чиглэлд давхардал үүссэн буюу 1 рейсээр 2 гүйцэтгэл гаргаж 2.5 сая төгрөгийн санхүүжилт илүү авсан, сурагчдын автобусаар иргэдийг тээвэрлэсэн зөрчил илэрлээ. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм”-ийн 3-ийн 3.7.6.4-д “хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл дотор замналын зураг болон бусад санамжуудыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан байх ба уг автобусаар зөвхөн хүүхэд тээвэрлэнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

БҮЛЭГ 3. Нийтийн тээврийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна

3.1.1. “Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ нь гэрээнд заасан хяналтыг хэрэгжүүлсэн байна

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 тоотоор баталсан “Дархан хотын дотор нийтийн тээврийн хэрэгсэл /автобус/-ээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдийн нөхөн олговрыг хуваарилах, санхүүжүүлэх түр журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3⁴², Дархан хотын доторх нийтийн тээвэрт хамтарч ажиллах

⁴² Хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд явж байгаа автобусанд нөхөн олговор эдлэх эрх бүхий иргэдийн зорчиж байгаа байдал, зорчигчийн тоог гаргах гэнэтийн тооллогыг сард хоёроос доошгүй удаа хийж, хяналт тавин баталгаажуулах

2020/A/001 тоот гэрээний 4.1⁴³-т заасны дагуу “Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавьжээ.

“Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ нь хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийн цаг, рейсийн нэгдсэн даалгаврыг сар бүр баталж, диспетчер рейсийн гүйцэтгэлд өдөр тутмын хяналт тавьж, жолоочийн замын хуудсанд гарын үсэг зурж, баталгаажуулан, тээврийн инженер рейсийн нэгтгэл, гүйцэтгэлийн биелэлтийг аймгийн ХБТХОХ-т хүргүүлсэн байна. Мөн гэрээний дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа автобусаар нөхөн олговор эдлэх эрх бүхий иргэдийн тоо, баталсан чиглэл, маршрутаар явж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор гэнэтийн тооллогыг сард хоёроос доошгүй удаа хийж баталгаажуулсан байлаа. Үүнээс үзэхэд “Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллажээ.

Харин Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01-A/131 тоот захирамжийн дагуу зорчигч тээврийн үйлчилгээг оновчтой, хүртээмжтэй зохион байгуулж, хяналт тавих чиг үүргийг аймгийн Автотээврийн төвд шилжүүлсэн байна.

3.1.2. Нийтийн тээврийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна

Автотээврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1⁴⁴-т гэж заасны дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Дархан-Уул аймгийн Автотээврийн төвөөс нийтийн тээврийн үйлчилгээнд 2020, 2021 онд хяналт шалгалт огт хийгээгүй байна. Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас нөхөн олговрын санхүүжилт, үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийгээгүй нь ковид-19 цар тахал гарч 2020-2021 онд бүх нийтийн хатуу хөл хорио, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой байв.

Аудитаар аймгийн Замын цагдаагийн тасгаас авсан лавлагаагаар “Элит хөгжил” ХХК-ийн нийтийн тээврийн том оврын автобуснууд нь 2020-2022 онд нийт 44 удаагийн зөрчил бүртгэгдсэнээс 3 нь зам тээврийн осол гарган зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцуулсан байна.

3.2. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

3.2.1. Компанийн зүгээс техникийн ашиглалт, цаг ашиглалт зэрэгт өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлжээ

Аудитаар компанийн дотоод хяналтын баримт материалыг шалгахад техникийн болон ажилтнуудын цаг ашиглалт, ХАБЭА-ын давтан зааварчилгааг өдөр тутам өгч, баталгаажуулснаас өөр хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мөн шинээр ажилд орж байгаа ажилчдад тухайн ажлын байрны талаарх зааварчилгааг өгч ажилласан эсэхийг шалгахад холбогдох баримтаар нотлогдоогүй болно.

⁴³ Тээвэрлэлтийн явц байдалд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ-аар хамтран хийж илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

⁴⁴ “Автотээврийн салбарын үйл ажиллагаанд тавих захиргааны хяналтыг автотээврийн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын мэргэжлийн хяналтын алба, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ”

3.2.2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөн олговрын 1,875.4 сая төгрөгийн санхүүжилтийг байршуулаагүй байна

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁴⁵, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 5 дугаар зүйлийн 5.1⁴⁶-т заасны дагуу төсвөөс авсан санхүүжилтийг мэдээлэх үүрэгтэй байна.

Аудитаар хууль, журамд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан эсэхийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд 3, 2021 онд 2, нийт 5 улирлын мэдээллээ хугацаа хоцроосон, үнэн зөв мэдээлээгүй байв. Аудитын явцад 2020 оны 1,031.3 сая, 2021 оны 844.1 сая, нийт 1,875.4 сая төгрөгийн нөхөн олговрын санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байсныг залруулга хийлгэсэн болно.

Цаашид төсвөөс авсан санхүүжилтийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх шаардлагатай байна.



⁴⁵ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

⁴⁶ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор энэ журмын 19 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлнэ.

Ирүүлсэн санал:



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059 Утас: 7037-7323
Факс: 7037-7121, Цахим шуудан: info@darkhan.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gov.mn

2022.12.02 № 5-10/1736
танай _____-ны № _____-т

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Нийтийн тээврийн үйлчилгээний санхүүжилт, үр
дүнд”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төслөөр ирүүлсэн алдаа, зөрчлийн
санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ... хуудастай.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА _____ П.БАТСҮХ

4522103334

"НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ, ҮР ДҮН" АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ТАЙЛБАР

№	Аудитын чиглэл/асуулт	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар
A	1	6
1	1.1.2. Нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн үү?	Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2021 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үндэслэн Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2021-2024 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан тул хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмж тусгах боломжгүй хасуулах саналтай.
2	1.1.3. Нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой үнэлсэн үү?	Тайланг тухай бүр журмын дагуу үнэлсэн.
3	1.2.1. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдтэй хууль журамд заасны дагуу гэрээ байгуулсан үү?	Орон нутагт нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлэх Нийтийн тээврийн үйлчилгээний тохирлын гэрчилгээ зөвшөөрөлтэй нэг аж ахуйн нэгж байгаа нь "Элит хөгжил" ХХК нь байна. Үйлчилгээ эрхлэгч байгууллагын өмнөх жилүүдийн ажил гүйцэтгэсэн гэрээний хэрэгжилтийг үндэслэн 2020 онд гэрээ байгуулсан. 2023 онд төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийг тодорхойлно.
4		Хэрэгжүүлж ажиллана
5	1.2.3. Гэрээний хэрэгжилтийг бодитой дүгнэсэн үү?	Гэрээг жил бүр санхүүжилтийн гэрээ, нөхөн олговрын гүйцэтгэл, сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үндэслэн бодит гүйцэтгэлээр дүгнэдэг.
6	2.1.1. Нийтийн тээврийн чиглэлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тогтоож, баталсан үү?	Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйл Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх 7.1.5 дахь заалт "Хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээгээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгөөр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх" Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтад тус чиглэл хамаарахгүй болно.
7	2.1.2. Хуулийн этгээд тогтоосон чиглэлийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна үү?	Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2016 оны 94 дүгээр тогтоолоор баталсан "Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын дүрэм"-д заасан чиг үүргийн дагуу орон нутгийн авто замын шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээний судалгааг гаргаж, батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу тэмдэг, тэмдэглэгээг хийж байна.
8	2.1.3. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон үнэ, тариф үндэслэлтэй байна үү?	Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ болон "Элит хөгжил" ХХК-ний 2020, 2021 онуудад байгуулсан Зорчигч тээвэрлэлтийн гэрээний хоёрдугаар хэсэгт тусгагдсан Автотээврийн тухай хууль тогтоомж, журмыг үндэслэн үнэ тарифыг гэрээний 6-р хэсэгт том хүн-300 төгрөг, хүүхэд-200 төгрөгөөр тусгаж гэрээ байгуулан мөрдөн ажилласан.
9	2.1.4. Тогтоосон чиглэл нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна үү?	Хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийн боломжоор үе шаттай хэрэгжүүлж ажиллана.
10	2.2.1. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь Монгол улсад мөрдөгдөж байгаа стандарт, шаардлага, шалгуурыг хангасан үү?	Засгийн газрын 55 дугаар тогтоол, Зам тээврийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн дагуу Авто тээврийн төв нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт Автотээврийн тухай хууль, тогтоомж стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллах чиг үүрэгтэй тул тухайн байгууллага хяналтыг хариуцна. Хасуулах саналтай.
11	2.2.2 Тээврийн хэрэгсэл нь техникийн стандарт шаардлагыг хангаж байна үү?	Засгийн газрын 55 дугаар тогтоол, Зам тээврийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн дагуу Авто тээврийн төв нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт Автотээврийн тухай хууль, тогтоомж стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллах чиг үүрэгтэй тул тухайн байгууллага хяналтыг хариуцна. Хасуулах саналтай.
12	2.3.1. Санхүүжилтийг бодитой тооцож, төлөвлөсөн үү?	2023 оны төсвийн төсөлд 68.0 сая төгрөгийн ухаалг системийн хөрөнгийг тусгасан боловч санхүүжилт батлагдаагүй бөгөөд цаашид хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж хэрэгжүүлж ажиллана.
	2.3.2. Санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байна үү?	
13	3.2.2 Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан үү?	Хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжүүлж ажиллана.

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭСЛТИЙН ДАРГА

П.БАТСҮХ

БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭСЛТИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ч.УНДРАХ



Тайланд тусгасан тэмдэглэл:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫГ
ТАЙЛАНД ТУСГАСАН ТЭМДЭГЛЭЛ

Холбогдох байгууллагын санал	Тайлбар
Бүлэг №1: 1.1.2. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1-ийн зорилтыг арга хэмжээ, хүрэх түвшинд тусгаагүй, хүрэх түвшнийг суурь түвшинтэй уялдуулаагүй, хэрэгжилтийг бодитой тайлагнаагүй байна гэснийг хасуулах саналтай байна. Тайлбар: Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2021 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үндэслэн Монгол улсын Засагийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2021-2024 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан тул хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмж тусгах боломжгүй. 1.1.3. Бодлогын баримт бичгийн зарим арга хэмжээний төлөвлөлтийг оновчтой боловсруулаагүйгээс хэрэгжилтийг хүрэх түвшинтэй уялдуулж тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг журмын дагуу үнэлээгүй байна. Тайлбар: Тайланг тухай бүр журмын дагуу үнэлсэн. 1.2.3. Аудитаар хамтран ажиллах гэрээг гэрээ дүгнэсэн акттай тулган шалгахад гэрээнд заасан захиалагч, хэрэгжүүлэгч, тээвэрлэгч талын 27 үүрэг тусгагдсан бөгөөд үүрэг тус бүрээр биелэлтийг дүгнээгүй байна. Тайлбар: Гэрээг жил бүр санхүүжилтийн гэрээ, нөхөн олговрын гүйцэтгэл, сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үндэслэн бодит гүйцэтгэлээр дүгнэдэг. Бүлэг №2: 2.1.1. Нийтийн тээврийн чиглэлийг Дархан сумын Засаг дарга тогтоож, баталсан. Дархан сумын нийтийн тээврийн "Мангирт-Хабитат", хүүхдийн автобусны чиглэлийг эрх бүхий этгээд батлаагүй. Тайлбар: Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйл Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх 7.1.5 дахь заалт "Хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгөөр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх" Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтад тус чиглэл хамаарахгүй болно. 2.1.3. Нийтийн тээвэр /автобус/-ийн үйлчилгээний үнийг, хамтран ажиллах гэрээнд тусгаагүй байна. Тайлбар: Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ болон "Элит хөгжил" ХХК-ний 2020, 2021 онуудад байгуулсан Зорчигч тээвэрлэлтийн гэрээний хоёрдугаар хэсэгт тусгагдсан Автотээврийн тухай	1.1.2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг, зорилттой уялдуулаагүй нь хангалттай болон зохистой баримтаар нотлогдож байгаа бөгөөд тайлангийн төсөлд үндэслэлгүй тайлбар ирүүлсэн тул тайланд хэвээр үлдээж, зөвлөмж өгөв 1.1.3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой үнэлээгүй нь хангалттай болон зохистой баримтаар нотлогдож байгаа бөгөөд тайлангийн төсөлд үндэслэлгүй тайлбар ирүүлсэн тул тайланд хэвээр үлдээж, зөвлөмж өгөв. 1.2.3. Захиалагч, хэрэгжүүлэгч, тээвэрлэгчтэй хамтран ажиллах гэрээний биелэлтийг үүрэг тус бүрээр нь дүгнэсэн нь баримтаар нотлогдохгүй байгаа тул хэвээр үлдээж, зөвлөмж өгөв 2.1.1. Дархан хот доторх нийтийн тээвэрт хамтарч ажиллах /2020-A/001/ тоот гэрээний 2.2-т "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний маршрут нь гэрээний хавсралтаар батлагдах бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг болно" гэж заасан бөгөөд, ирүүлсэн тайлбар нь үндэслэлгүй тул тайланд хэвээр үлдээж, зөвлөмж өгөв. 2.1.3. Аудитын шалгалтаар Дархан хот доторх нийтийн тээвэрт хамтарч ажиллах /2020-A/001, НТНО+2021/01/ тоот гэрээнд үйлчилгээний үнэ, тариф тусгаагаагүй байсан тул тайланд хэвээр үлдээж, зөвлөмж өгөв.

хууль тогтоомж, журмыг үндэслэн үнэ тарифыг гэрээний 6-р хэсэгт том хүн-300 төгрөг, хүүхэд-200 төгрөгөөр тусгаж гэрээ байгуулан мөрдөн ажилласан. 2.2.1. Жолооч нарыг үйлчилгээнд гарахын өмнө эмчийн үзлэгт хамруулаагүй, хүний нөөцийн мэдээллийг “Зам тээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем”-д бүртгүүлээгүй, нийтийн тээврийн хэрэгсэл дотор чиглэл, замналын зураглал, тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг заалт байхгүй, тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгсэлд учирсан гэмтлийг арилгах, шуурхай арга хэмжээний бүдүүвч ашигладаггүй, жолооч кондукторын түр амрах, хооллох байргүй байна гэснийг хасуулах саналтай байна. • Тайлбар: Засгийн газрын 55 дугаар тогтоол, Зам тээврийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн дагуу Авто тээврийн төв нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт Автотээврийн тухай хууль, тогтоомж стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллах чиг үүрэгтэй тул тухайн байгууллага хяналтыг хариуцна. 2.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн зорчих нөхцөлийг бүрдүүлж тусгай тоног төхөөрөмжөөр тоноглоогүй тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна хасуулах саналтай байна. • Тайлбар: Засгийн газрын 55 дугаар тогтоол, Зам тээврийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн дагуу Авто тээврийн төв нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт Автотээврийн тухай хууль, тогтоомж стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллах чиг үүрэгтэй тул тухайн байгууллага хяналтыг хариуцна.	2.2.1. Дархан хотын доторх нийтийн тээвэрт хамтран ажиллах гэрээний захиалагч, хэрэгжүүлэгч талын эрх, үүрэг хэсгийн 3.3-д “Тухайн чиглэлд нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагааг зохицуулах, үйлчилгээнд мөрдөх стандарт, журмын хэрэгжилтэд хяналт тавих ...”, 4.2-д “Хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, стандарт хангасан зогсоол буудал, тэмдэг, тэмдэглэгээгээр бүрэн хангах талаар хамтарч ажиллах” гэж заасан тул тайланд хэвээр үлдээж, зөвлөмж өгөв. 2.2.2. Дархан хотын доторх нийтийн тээвэрт хамтран ажиллах гэрээний захиалагч, хэрэгжүүлэгч талын эрх, үүрэг хэсгийн 3.3-д “Тухайн чиглэлд нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагааг зохицуулах, үйлчилгээнд мөрдөх стандарт, журмын хэрэгжилтэд хяналт тавих ...”, 4.2-д “Хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, стандарт хангасан зогсоол буудал, тэмдэг, тэмдэглэгээгээр бүрэн хангах талаар хамтарч ажиллах” гэж заасан тул тайланд хэвээр үлдээж, зөвлөмж өгөв.
---	---

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

С.САНЖААЖАВ

Г.БАТМЯГМАР

Н.ОТГОНЦЭЦЭГ

З.МӨНГӨНЦЭЦЭГ

О.МЯГМАРСҮРЭН

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1-ийн зорилтыг хүрэх түвшин, арга хэмжээтэй харилцан уялдаагүй боловсруулсан байна.
2. Бодлогын баримт бичгийн зарим арга хэмжээний төлөвлөлтийг оновчтой боловсруулаагүйгээс хэрэгжилтийг хүрэх түвшинтэй уялдуулж тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг журмын дагуу үнэлээгүй байна.
3. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч ААН-ийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.
4. Хамтран ажиллах гэрээ нь хуульд нийцэж байгаа боловч нэмэлт гэрээнд хүчин төгөлдөр бус журмыг мөрдлөг болгохоор тусгасан байна
5. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг эрх бүхий этгээд баталгаажуулаагүй байна.
6. Нийтийн тээврийн үйлчилгээг тогтоосон чиглэлийн дагуу гүйцэтгэж байна.
7. Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ, тариф нийслэлийн болон төвийн бүсийн аймгуудтай ойролцоо түвшинд байна.
8. Тогтоосон чиглэл нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа боловч зогсоолын байгууламж Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартын шаардлагыг хангахгүй байна.
9. Нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа жолооч, тээврийн хэрэгслүүд нь стандартын шаардлагыг хангахгүй байна.
10. Нийтийн тээврийн төсвийн төлөвлөлт үндэслэлгүй, санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр тооцож олгоогүй байна.
11. Нийтийн тээврийн үйлчилгээнд мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна.
12. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг дарга Б.Азжаргалд зөвлөх нь:

1. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1-т нэмэлт өөрчлөлт оруулж, цаашид бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу боловсруулах
2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих үе шатны хяналтыг сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох журмын дагуу үнэлэх
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2⁴⁷-т зааснаар төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан ААН-тэй ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах

⁴⁷ “тендер шалгаруулалт” гэж хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг энэ хуульд заасан журмын дагуу шалгаруулж, бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах ажиллагааг;

4. Нийтийн тээврийн үйлчилгээнд мөрдөж байгаа журмыг хуульд нийцүүлж дахин боловсруулах
5. Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээг заасан хугацаанд тогтмол дүгнэж байх
6. “Замын хөдөлгөөний дүрэм”-ийн нэгдүгээр хавсралтын 5.21-д заасан “Чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал” тэмдгийг тогтоосон чиглэлийн цэгүүдэд бүрэн байршуулах
7. Нийтийн тээврийн чиглэлийг баталж, хамтран ажиллах гэрээнд хавсаргаж байх
8. Нийтийн тээвэр /автобус/-ийн үйлчилгээний үнэ тарифыг хамтран ажиллах гэрээнд тусгаж, Автотээврийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ийг мөрдөж ажиллах.
9. Монгол Улсын стандарт, нийтийн тээвэр замналын зогсоол MNS 5879:2012 стандартыг хэрэгжүүлж ажиллах
10. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/65 тоот тушаалаар баталсан нийтийн тээврийн ангилал үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS5012:2021 стандартын 6 дугаар зүйлийн 6.9, 6.11, 7 дугаар зүйлийн 7.7, 7.8, 9 дүгээр зүйлийн 9.4.4, 9.5 дахь заалтуудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд зорчих нөхцөлийг бүрдүүлсэн тусгай тоноглолыг стандартад нийцүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих
12. Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг бүртгэл, хяналтын системийг нэвтрүүлэх
13. Төсвөөс авсан санхүүжилтийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн хугацаанд бүрэн байршуулж байгаад хяналт тавьж ажиллах

“Элит хөгжил” ХХК-д:

1. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/65 тоот тушаалаар баталсан нийтийн тээврийн ангилал үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS5012:2021 стандартын 6 дугаар зүйлийн 6.9, 6.11, 7 дугаар зүйлийн 7.7, 7.8, 9 дүгээр зүйлийн 9.4.4, 9.5 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах
2. Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт, зөв оруулж байх

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хавсралт 1

Ажлын баримтын нэр:	Алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл
Аудитын код:	ДАА-2022/38-ШТА-ГА
Аудитын нэр:	“Нийтийн тээврийн үйлчилгээний санхүүжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

/Сая.төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Хэрэгжилт тооцох хугацаа		Мөнгөн дүн	Хариуцах аудитор	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
		Хүлээлгэн өгсөн	Барагдуулах				Албан тушаал	Овог нэр
А	1	5	6	7		8	9	10
Төлбөрийн акт								
1	Сурагч тээврийн үйлчилгээг гэрээний дагуу хэрэгжүүлэгч “Элит хөгжил” ХХК сурагчийн автобусаар нийтийн тээврийн үйлчилгээнд давхар явж 1 рейсээр 2 гүйцэтгэл гаргаж, төсвөөс 2,507,962.0 төгрөгийн санхүүжилт илүү авсан байна	2022.10.21	2022.12.05	2.5	С.Санжаажав	Төлбөрийн акт тогтоох	“Элит хөгжил” ХХК-ийн ерөнхий захирал	З.Бадрал
Дүн				2.5				
Албан шаардлага								
1	“Элит хөгжил” ХХК-ийн нийтийн тээврийн үйлчилгээнд “Д” ангиллын мэргэшсэн жолоочийн эрхгүй 12 жолооч ажиллаж байна.	2022.10.21	2023.05.30	-	Н.Отгонцэцэг	Албан шаардлага өгөх	Автотээврийн төвийн дарга, “Элит хөгжил” ХХК-ийн гүйцэтгэх захирал	Б.Батсайхан, Б.Анхбаяр
2	“Элит хөгжил” ХХК-ийн барилга байгууламж болон автотээврийн хэрэгсэлд байгаа 34 ширхэг гал унтраагуурын ашиглалтын хугацаа дууссан байна.	2022.10.21	2022.11.30	-	Н.Отгонцэцэг	Албан шаардлага өгөх	“Элит хөгжил” ХХК-ийн гүйцэтгэх захирал	Б.Анхбаяр
3	Техникийн хяналтын үзлэгээр тэнцээгүй, гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтад ороогүй нийт 9 том оврын автобус нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж, замын хөдөлгөөнд оролцож байна.	2022.10.21	2022.11.30	-	Г.Батмягмар	Албан шаардлага өгөх	“Элит хөгжил” ХХК-ийн гүйцэтгэх захирал	Б.Анхбаяр

Дүн				-				
Зөвлөмж								
1	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1-ийн зорилтыг арга хэмжээ, хүрэх түвшинд тусгаагүй, хүрэх түвшнийг суурь түвшинтэй уялдуулаагүй, хэрэгжилтийг бодитой тайлагнаагүй.	2022.10.25	2023.05.01	-	З.Мөнгөнцэцэг	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
2	Бодлогын баримт бичгийн зарим арга хэмжээний төлөвлөлтийг оновчтой боловсруулаагүйгээс хэрэгжилтийг хүрэх түвшинтэй уялдуулж тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг журмын дагуу үнэлээгүй.	2022.10.25	2023.05.01	-	З.Мөнгөнцэцэг	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
3	Хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний үйл ажиллагааг сонгон шалгаруулалт зарлалгүйгээр “Элит хөгжил” ХХК-ийн гаргасан хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулсан	2022.10.25	2023.05.01	2,000.0	Х.Сувдмаа	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
4	Хүчин төгөлдөр бус журмаар нийтийн тээврийн үйл ажиллагааг зохицуулж, мөрдөж ажилласан байна.	2022.10.25	2023.05.01	-	Х.Сувдмаа	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
5	Аудитаар хамтран ажиллах гэрээг гэрээ дүгнэсэн акттай тулган шалгахад гэрээнд заасан захиалагч, хэрэгжүүлэгч, тээвэрлэгч талын 27 үүрэг тусгагдсан бөгөөд үүрэг тус бүрээр биелэлтийг дүгнээгүй байна.	2022.10.25	2023.05.01	-	Х.Сувдмаа	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
6	Нийтийн тээврийн чиглэлийг Дархан сумын Засаг дарга тогтоож, баталсан. Дархан сумын нийтийн тээврийн "Мангирт-Хабитат", сурагчдын автобусны чиглэлийг эрх бүхий этгээд батлаагүй байна	2022.10.25	2023.05.01	-	О.Мягмарсүрэн	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
7	Алслагдсан гэр хорооллын дундах нийтийн тээврийн чиглэлийн зогсоолын цэгт "Замын хөдөлгөөний дүрэм"-ийн 5.21-т заасан тэмдгийг бүрэн байршуулаагүй	2022.10.25	2023.05.01	-	О.Мягмарсүрэн	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
8	Нийтийн тээвэр /автобус/-ийн үйлчилгээний үнийг, хамтран ажиллах гэрээнд тусгаагүй байна	2022.10.25	2023.05.01	-	Ч.Гантулга	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
9	Нийтийн тээвэр /автобус/-ийн замналын зогсоолын байгууламжийг стандартын дагуу барьж, мэдээ, мэдээллийн самбаргүй байна.	2022.10.25	2023.05.01	-	Ч.Гантулга	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
10	Жолооч нарыг үйлчилгээнд гарахын өмнө эмчийн үзлэгт хамруулаагүй, хүний нөөцийн мэдээллийг “Зам тээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем”-д	2022.10.25	2023.05.01	-	Н.Отгонцэцэг	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал

	бүртгүүлээгүй, нийтийн тээврийн хэрэгсэл дотор чиглэл, замналын зураглал, тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг заалт байхгүй, тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгсэлд учирсан гэмтлийг арилгах, шуурхай арга хэмжээний бүдүүвч ашигладаггүй, жолооч кондукторын түр амрах, хооллох байргүй байна.							
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн зорчих нөхцөлийг бүрдүүлж тусгай тоног төхөөрөмжөөр тоноглоогүй тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна.	2022.10.25	2023.05.01	-	Г.Батмягмар	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
12	Нийтийн тээврийн төсвийн төлөвлөлт үндэслэлгүй, санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр тооцож олгоогүй байна.	2022.10.25	2023.05.01	-	С.Батцэцэг С.Санжаажав	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
13	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд 3, 2021 онд 2, нийт 5 улирлын мэдээллээ хугацаа хоцроосон, 2020 оны 1,031.3 сая, 2021 оны 844.1 сая, нийт 1,875.4 сая төгрөгийн нөхөн олговрын санхүүжилтийн мэдээлээгүй	2022.10.25	2023.05.01	-	Б.Алтанзул	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн Засаг дарга	Б.Азжаргал
14	Жолооч нарыг үйлчилгээнд гарахын өмнө эмчийн үзлэгт хамруулаагүй, хүний нөөцийн мэдээллийг “Зам тээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем”-д бүртгүүлээгүй, нийтийн тээврийн хэрэгсэл дотор чиглэл, замналын зураглал, тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг заалт байхгүй, тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгсэлд учирсан гэмтлийг арилгах, шуурхай арга хэмжээний бүдүүвч ашигладаггүй, жолооч кондукторын түр амрах, хооллох байргүй байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн зорчих нөхцөлийг бүрдүүлж тусгай тоног төхөөрөмжөөр тоноглоогүй тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна.	2022.10.25	2023.05.01	-	Г.Батмягмар Н.Отгонцэцэг	Зөвлөмж өгөх	Элит хөгжил ХХК	З.Бадрал
15	шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд 3, 2021 онд 2, нийт 5 улирлын мэдээллээ хугацаа хоцроосон, үнэн зөв мэдээлээгүй байв. Аудитын явцад 2020 оны 1,031.3 сая, 2021 оны 844.1 сая, нийт 1,875.4 сая төгрөгийн нөхөн олговрын санхүүжилтийн мэдээлээгүй байна	2022.10.25	2023.05.01	1,875.4	Б.Алтанзул	Зөвлөмж өгөх	Элит хөгжил ХХК	З.Бадрал
Зөвлөмжийн дүн				3,875.4				
Алдаа зөрчлийн нийт дүн				3,877.9				

